



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАНИЛЦУУЛГА



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn

1.ӨРХ, ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 2015 оны жилийн эцсийн байдлаар манай аймаг 16308, үүнээс эрэгтэй 8246, эмэгтэй 8062 хүнтэй боллоо. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүн ам 417 буюу 2.6 хувиар, үүнээс эрэгтэй 307 буюу 3.9 хувиар, эмэгтэй 110 буюу 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Нийт хүн амын 50.6 хувийг эрэгтэйчүүд, 49.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт хүн амын 33.3 хувийг 0-15 насны хүүхэд, 61.3 хувийг хөдөлмөрийн насны буюу 16-59 насны хүмүүс, 5.4 хувийг өндөр настнууд буюу 60 ба түүнээс насны хүмүүс эзэлж байна.

Тайлант онд 4987 өрх тоологдсон нь өмнөх оноос 5.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шилжин ирсэн хүн 799 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 54 буюу 6.8 хувиар өсч, шилжин явсан хүн 677 болж өмнөх оны мөн үеийнхээс 71 буюу 9.5 хувиар буурсан байна. Шилжин ирэгсдийн 295 буюу 36.9 хувь нь Улаанбаатар хотоос, 131 буюу 16.4 хувь нь Дорноговь аймгаас, 112 буюу 14.0 хувь нь Дундговь аймгаас, 261 буюу 32.7 хувь нь бусад аймгаас ирсэн байна. Шилжин явагчдын 435 буюу 64.3 хувь нь Улаанбаатар хотруу, 59 буюу 8.7 хувь нь Дундговь аймаг руу, 55 буюу 8.1 хувь Дорноговь аймаг руу, 128 буюу 18.9 хувь нь бусад аймаг руу явсан байна.

Аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 22, үүнээс эмэгтэй 8, хагас өнчин хүүхэд 182, үүнээс эмэгтэй 78 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс бүтэн өнчин хүүхэд 5 буюу 18.5 хувиар буурсан, хагас өнчин хүүхэд 5 буюу 2.8 хувиар өссөн үзүүлэлт гарчээ. Мөн өрх толгойлсон эцэг, эх 745 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 18 буюу 2.5 хувиар өссөн байна. Ганц бие өндөр настан 271 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 109 буюу 67.3 хувиар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 669 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 90 буюу 15.5 хувиар тус тус өссөн гарлаа.

2015 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 441 хүүхэд эхээс мэндэлсний 207 нь хүү, 234 нь охин байлаа. Нийт 90 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 78, цуцалсан гэр бүл 24, үрчлэгдсэн хүүхэд 7 бүртгэгдлээ. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад төрөлт 54 буюу 11.0 хувиар, нас баралт 20 буюу 18.2 хувиар, үрчлэгдсэн хүүхдийн тоо 1 буюу 12.5 хувиар тус тус буурч, бүртгүүлсэн гэр бүл 16 буюу 25.8 хувиар, цуцалсан гэр бүлийн тоо 4 буюу 20.0 хувиар өссөн байна.

2015 онд хөдөлмөрийн насны хүн ам 9993, үүнээс 5827 нь ажиллагчид байгаа нь 58.3 хувийг эзэлж байна.

Хүн амын тоог сумдаар мэдээлбэл:

Сумд		2014 он	2015 он	Өсөлт Бууралт	Хувь
Баянтал	Нийт хүн ам	1084	1153	69	6.4
	Эрэгтэй	548	585	37	6.8
	Эмэгтэй	536	568	32	6.0
Сүмбэр	Нийт хүн ам	11609	11901	292	2.5
	Эрэгтэй	5761	5974	213	3.7
	Эмэгтэй	5848	5927	79	1.4
Шивээ- говь	Нийт хүн ам	3198	3254	56	1.8
	Эрэгтэй	1628	1687	59	3.6
	Эмэгтэй	1570	1567	-3	-0.2
Дүн	Нийт хүн ам	15891	16308	417	2.6
	Эрэгтэй	7937	8246	309	3.9
	Эмэгтэй	7954	8062	108	1.4

2015 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог
насны бүлэглэлээр үзүүлбэл:

Насны бүтэц	Аймгийн дүн	Баянтал сум	Сүмбэр сум	Шивээговь сум
0-4.	2195	170	1561	464
5-9.	1747	112	1286	349
10-14.	1229	91	908	230
15-19	1310	97	957	256
20-24	1367	92	1005	270
25-29	1655	105	1189	361
30-34	1382	101	981	300
35-39	1174	84	854	236
40-44	1086	77	805	204
45-49	947	63	695	189
50-54	761	50	561	150
55-59	567	54	408	105
60-64	321	23	241	57
65-69	191	12	148	31
70-74	144	8	107	29
75-79	132	8	108	16
80-84	57	6	46	5
85-89	25	-	24	1
90-94	18	-	17	1
95-99	-	-	-	-
100+	-	-	-	-
Нийт	16308	1153	11901	3254

Насны бүлэглэлээс харахад 70 ба түүнээс дээш настан 376, 80 ба түүнээс дээш настан 100, аймгийн хамгийн өндөр настан нь Сүмбэр сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт амьдарч байна.

Өрхийн тоог сумдаар үзүүлбэл:

Сумд	Он		Өсөлт бууралт	Хувь
	2014	2015		
Баянтал	331	361	30	9.1
Сүмбэр	3423	3605	182	5.3
Шивээговь	995	1021	26	2.6
Дүн	4749	4987	238	5.0

Нийт өрхийг байршлаар нь авч үзвэл:

Аймгийн төвд 2946 өрх буюу нийт өрхийн 59.0 хувь

Сумын төвд 871 өрх буюу нийт өрхийн 17.5 хувь

Хөдөө багт 1170 өрх буюу нийт өрхийн 23.5 хувь нь тус тус амьдарч байна.

2015 онд тоологдсон 4987 өрхийг сууцны төрлөөр нь авч үзвэл:

- Гэрт амьдардаг өрх	1983
- Байшинд амьдардаг өрх	2947
Орон сууцанд амьдардаг өрх	1872
Бие даасан тохилог сууцанд амьдардаг өрх	62
Сууцны тусдаа байшинд амьдардаг өрх	793
Нийтийн байранд амьдардаг өрх	220
- Бусад сууцанд амьдардаг өрх	57 байна.

1.2. Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээгээр бүтэн өнчин хүүхэд 22 байгаагийн 8 нь эмэгтэй. Хагас өнчин 182 хүүхэд байдгаас 0-4 настай 18, 5-9 настай 35, 10-14 настай 56, 15-17 настай хүүхэд 73 байна. Хагас өнчин хүүхдийн 78 буюу 42.9 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад бүтэн өнчин хүүхэд 5 буюу 18.5 хувиар буурч, хагас өнчин хүүхэд 5 буюу 2.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 669 бүртгэгдсэнээс эмэгтэй 293, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 322 бүртгэгдсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх оны мөн үеийнхээс 90 буюу 15.5 хувиар өссөн мэдээтэй байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 0-14 насны 47 хүүхэд байна.

2015 онд ганц биеэрээ амьдарч байгаа өндөр настан өрхийн тоо 271 бүртгэгдсэн ба үүнээс 60 ба түүнээс дээш настай /эрэгтэй/ 64, 55 түүнээс дээш настай /эмэгтэй/ 207 өндөр настан амьдарч байна.

Аймгийн хэмжээнд өрх толгойлсон эмэгтэй 635 амьдарч байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 32 буюу 5.3 хувиар өссөн байна.

Үүний: 332 нь буюу 52.3 хувь нь 3 хүртэл хүүхэдтэй

264 нь буюу 41.6 хувь нь 3-5 хүүхэдтэй

39 нь буюу 6.1 хувь нь 6-аас дээш хүүхэдтэй хүмүүс байлаа.

1.3. Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн зарим үзүүлэлтүүдийг тайлант оны байдлаар авч үзвэл (Тайлант онд АДТүвшин Төвийн бүсэд 164300 төгрөг байлаа.)

Ядуу өрх 361, өрхийн гишүүд 1547 байгаа нь нийт өрхийн 7.2 хувийг, нийт хүн амын 9.5 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеийнхээс ядуу өрхийн тоо 15 буюу 3.9 хувиар, иргэд 52 буюу 3.3 хувиар буурсан байна.

Нийт ядуу өрхөөс нэн ядуу өрх 149, өрхийн гишүүд нь 685 байгаа нь нийт ядуу өрхийн 41.3 хувийг, ядуу өрхийн гишүүдийн 44.3 хувийг эзэлж байгааг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал нэн ядуу өрх 4 буюу 2.6 хувиар, өрхийн гишүүд 2 буюу 0.3 хувиар буурсан байна.

Ядуу иргэдийн 287 буюу 18.5 хувь нь боловсролгүй, 364 буюу 23.5 хувь нь ЕБС-д суралцагсад байна. Энэ онд орон гэргүй ядуу өрх 15 бүртгэгдсэний 13 буюу 86.7 хувь нь нэн ядуу өрх байлаа. Аймгийн хэмжээгээр ядуу өрхүүдэд 1.3 сая.төгрөгийн мөнгөн тусламж, 25.8 сая төгрөгийн бусад тусламжийг олгосон байна.

1.4. Жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 332 байгаагаас 187 эмэгтэй байгаа нь нийт ажилгүй иргэдийн 56.3 хувийг эзэлж байна.

Мөн хугацаанд нийт 300 хүн байнгын шинэ ажлын байраар хангагдсан байна. Үүний 171 нь буюу 57.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажил идэвхтэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл боловсролгүй иргэд 7 үүнээс эмэгтэй 4, бага боловсролтой 15 үүнээс эмэгтэй 9, суурь боловсролтой 22 үүнээс эмэгтэй 13, бүрэн дунд 170 үүнээс эмэгтэй 95, техникийн болон мэргэжлийн 30 үүнээс эмэгтэй 12, тусгай

мэргэжлийн дунд 21 үүнээс эмэгтэй 7, дипломын болон бакалаврын дээд 65 үүнээс эмэгтэй 48, магистр болон доктор 2 байна.

Ажил идэвхтэй хайгч ажилгүй иргэд 143 байгаагийн 57 буюу хувь 39.9 нь бүрэн дунд боловсролтой, 40 буюу 28.0 хувь нь бакалавр, түүнээс дээш боловсролтой иргэд байна.

Жилийн эцсийн байдлаар ажлын байрны захиалга 535 ирж, аймгийн Хөдөлмөрийн хэлтсээр 300 иргэн ажилд зуучлуулсны 171 нь эмэгтэйчүүд байлаа.

1.5. Тайлант онд Халамжийн хэлтсээс давхардсан тоогоор 4508 хүнд 1225.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт, халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээ авсан иргэдийн тоо 67 буюу 1.5 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн хэмжээ 1.1 сая төг буюу хувиар 0.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Халамжийн сангийн мэдээг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт		Хамрагдсан иргэдийн тоо		Олгосон мөнгөн дүн /сая.төг/	
		2014 он	2015 он	2014 он	2015 он
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		1440	1484	795.6	784.3
1	Халамжийн тэтгэвэр	340	307	391.4	384.4
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1100	1177	404.2	399.9
1	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	796	872	237.9	210.5
2	Ахмад настныг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	139	140	64.2	69.3
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	142	140	86.7	102.7
4	Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсөн, асарч буй иргэний тэтгэмж	23	25	15.3	17.4
Нийгмийн халамж үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж		3135	3024	430.7	440.8
1	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	1439	1321	81.6	79.8
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	265	220	57.9	52.8
3	Нийгмийн халамжийн үйлчилгээ	31	48	32.3	57.9
4	Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	252	250	76.9	68.9
5	Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	18	20	22.3	19.5
6	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1130	1165	159.7	161.8
Нийгмийн халамжийн сангийн дүн		4575	4508	1226.3	1225.3

2. ХӨДӨӨ АЖ АХУЙ

2.1 2015 оны жилийн эцсээр манай аймаг 379.5 мянган толгой малтай болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 40.0 мянган толгой буюу 11.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: Тэмээ 869 толгой, үхэр 12390 толгой, адуу 18149 толгой, хонь 169090 толгой, ямаа 178979 толгой тус тус тоологджээ.

Малын төрөл	Сумд			ДҮН
	Баянтал	Сүмбэр	Шивээговь	
Тэмээ	138	639	92	869
Адуу	3639	12990	1520	18149
Үхэр	1930	8879	1581	12390
Хонь	26200	123602	19288	169090
Ямаа	25467	132283	21229	178979
Бүгд	57374	278393	43710	379477

Аймгийн хэмжээнд 994 малтай өрх байгаагаас 673 малчин өрхийн 2316 ам бүлийн гишүүд тоологдсон ба нийт малчид 1160, үүнээс эмэгтэй малчид 535 буюу нийт малчдын 46.1 хувийг эзэлж байна

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл :

15-34 нас - 330 малчин буюу 28.4 хувь

35-59 нас- 684 малчин буюу 59.0 хувь

60 аас дээш насны - 146 малчин буюу 12.6 хувийг тус тус эзэлж байна.

Эрлийз, цэвэр үүлдрийн мал 9824, үүнээс “Сүмбэр” хонь 1335 толгой Сүмбэр - Монгол эрлийз хонь 62 толгой тоологдлоо.

Нийт малын дүнд цэвэр үүлдрийн тэмээ 21 буюу 0.2 хувь, цэвэр үүлдрийн адуу 39 буюу 0.4 хувь, эрлийз, цэвэр үүлдрийн үхэр 245 буюу 2.5 хувь, эрлийз, цэвэр үүлдрийн хонь 5642 буюу 57.4 хувь, эрлийз, цэвэр үүлдрийн ямаа 3877 буюу 39.5 хувийг эзэлж байна.

Малын тоо (толгойгоор)

Малын төрөл	2014 он	2015 он	Хувь	Зөрүү
Толгойн тоогоор	339438	379477	111.8	40039
Тэмээ	872	869	99.7	-3
Адуу	14968	18149	121.3	3181
Үхэр	10358	12390	119.6	2032
Хонь	152260	169090	111.1	16830
Ямаа	160980	178979	111.2	17999

2.2 2015 онд малтай өрх 994 бүртгэгдсэн бөгөөд энэ онд манай аймагт нэг мянгаас дээш мал тоолуулсан 95 малчин тоологдлоо.

Үүнд:

Сүмбэр сумын мянгат малчин 66

Баянтал сумын мянгат малчин 18

Шивээговь сумын мянгат малчин 10

Мянгат малчдаас хамгийн их малтай нь Баянтал сумын 1 дүгээр багийн иргэн Г.Мөнхбаяр /2757 толгой мал/, хамгийн их тэмээтэй Сүмбэр сумын 6 дугаар багийн иргэн З.Бадарч /131 толгой /, хамгийн их адуутай нь Сүмбэр сумын 5 дугаар багийн иргэн Г.Шүрэнчулуун /338 толгой/, хамгийн их үхэртэй нь Баянтал сумын 1 дүгээр багийн иргэн Б.Мянганбаяр /273 толгой /, хамгийн их хоньтой нь Сүмбэр сумын 5-р багийн иргэн Б.Бадамцэрэн /780 толгой/, Баянтал сумын 1 дүгээр багийн иргэн Г.Мөнхбаяр /780 толгой/, хамгийн их ямаатай нь Сүмбэр сумын 6 дүгээр багийн иргэн Б.Баярсайхан /648 толгой/ нар байлаа.

Малтай өрхийн малын тоог бүлэглэлтээр авч үзвэл:

10 хүртэл толгой малтай	23
11-30 толгой малтай	79
31-50 толгой малтай	69
51-100 толгой малтай	136
101-200 толгой малтай	157
201-500 толгой малтай	266
501-999 толгой малтай	169
1000-1499 толгой малтай	68
1500-2000 толгой малтай	13
2001 түүнээс дээш толгой малтай	14 өрх байна.

2.3 2015 онд аймгийн хэмжээнд төллөвөл зохих эх малын 91.0 хувь буюу 140877 мал төллөж, гарсан төл 143796, үүнээс 4061 төл хорогдож, 139735 төл бойжиж байна.

Бойжсон төлийг төрлөөр нь авч үзвэл:

Сумд	Төллөвөл зохих хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Төллөлт-ийн хувь	Хорогдсон төл	Бойжсон төл
Баянтал	24990	25305	101.3	156	25805
Сүмбэр	112553	98457	87.5	3609	96531
Шивээговь	17278	17115	99.0	296	17399
Дүн	154821	140877	91.0	4061	139735

2014 онд 3187 төл хорогдсон бол 2015 онд 4061 төл хорогдож өмнөх оны мөн үеийнхээс 874 буюу 27.4 хувиар өссөн ба нийт хорогдсон төлийн 58.2 хувийг ишиг, 38.6 хувийг хурга эзэлж байна.

2.4 2015 оны жилийн эцсийн байдлаар 1987 том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 345 буюу 17.4 хувиар өссөн байна.

Малын зүй бус хорогдол /толгой/

Он	Бүгд	Үүнээс:				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2010	15316	6	265	171	5993	8881
2011	314	8	15	8	171	112
2012	853	5	21	19	335	473
2013	1826	3	23	21	677	1104
2014	1642	38	49	70	595	890
2015	1987	7	58	77	858	987

Малын зүй бус хорогдлыг сумдаар үзүүлбэл:

Сумд	Хорогдсон том мал		Оны эхний малд эзлэх хувь	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Баянтал	79	106	0.1	0.03
Сүмбэр	1466	1677	0.6	0.5
Шивээговь	97	204	0.2	0.1
Дүн	1642	1987	0.3	0.6

2.5 Оны эцэст 171.2 мянган хээлтэгч мал байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 16.4 толгой буюу 10.6 хувиар өсчээ.

Хээлтэгч малыг өмнөх онтой харьцуулбал: /толгой/

Сумд	Он		Зөрүү	Хувь
	2014	2015		
Баянтал	24990	24301	-689	97.2
Сүмбэр	112553	128966	16413	114.6
Шивээговь	17278	17921	643	103.7
Дүн	154821	171188	16367	110.6

2.6 Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн эцсийн мэдээнээс харахад 2015 онд аймгийн хэмжээнд төмс 49.1 тонн, хүнсний ногоо 103.1 тонн нийт 152.2 тонн ургац хураасан байна. Мөн тэжээлийн ургамал 3.0 тонн, бэлтгэсэн өвс 1775.9 тн, гар тэжээл 20.7 тн, бэлтгэсэн дарш 1.3 тн, хужир шүү 293.8 тн-ыг бэлтгэж авсан байна.

Хураасан ургац, тонноор

дд	Үзүүлэлт	2014 он	2015 он	Өсөлт бууралт
1	Хураасан төмс	56.3	49.4	-6.9
2	Хураасан хүнсний ногоо	68.3	103.1	34.8
3	Хураасан тэжээлийн ургамал	2.4	3.0	0.6
4	Бэлтгэсэн өвс	947.8	1775.9	828.1
5	Бэлтгэсэн дарш	-	1.3	1.3
6	Гар тэжээл	65.9	20.7	-45.2
7	Хужир шүү	-	293.8	293.8

2.7 Хүн ам, мал, хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын 2015 оны тооллогоор аймгийн дүнгээр гахай, тахиа, туулай 3305 тоологдлоо.

Нийт 336 гахай үүнээс:

Хээлтэгч 93
Хээлтүүлэгч 44
Бусад 199

Нийт 2956 тахиа үүнээс:

Үндсэн эх 2817
Хээлтүүлэгч 132
Бусад 7

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад гахай 10 буюу 3.1 хувиар, тахиа 2206 буюу 3.9 дахин өссөн байна.

3. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА

3.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээг ШОНУ, Ус-Ду, Тохижилт-Сүмбэр, Талын илч, Илчлэг-шивээ, Илчит сансар зэрэг томоохон аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг. 2015 оны жилийн эцсийн байдлаар эдгээр аж ахуйн нэгж байгууллага нь 37.6 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 39.1 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Шивээ-Овоо Хувьцаат компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 95.0 хувийг, нийт борлуулалтын 95.2 хувийг гүйцэтгэсэн байна.

Шивээ-Овоо хувьцаат компани нь зах зээл дээр 1 тонн нүүрсийг 26642 төгрөгөөр худалдаалж байна.

Шивээ-Овоо хувьцаат компаний борлуулалтын үзүүлэлтийг танилцуулбал:

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилийн эхнээс гүйцэтгэл	
		2014 он	2015 он
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	Сая.төг	36326.1	37192.0
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	Мян.тн	2012.1	2060.1
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	Мян.тн	1929.8	1772.9
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр/	Сая.төг	38176.1	35699.0
Ажиллагсдын тоо	Хүн	495	515

ШОНУурхайн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт мөнгөн дүнгээр 6.5 хувиар буурч,
- Бүтээгдэхүүн борлуулалт мөнгөн дүнгээр 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна

3.2 Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир татан зайлуулах чиглэлээр Ус-Ду, Талын Илч, Илчлэг Шивээ, Илчит сансар зэрэг ОНӨҮГ-ууд үйл ажиллагаа явуулж байна. 2015 онд ус дулааны эдгээр байгууллагууд нь нийт 1859.8 сая төгрөгийн үйлдвэрлэл явуулсан бөгөөд үүнээс 168.8 сая.төгрөгийн хэрэглээний халуун ус, цэвэр ус түгээж, 67.0 сая төгрөгийн бохирыг татан зайлуулсан байна.

3.3 2015 онд 4 захиалагч байгууллага 4 гүйцэтгэгч байгууллагаар 18 объектын барилга угсралт, их засварын ажил гүйцэтгүүлсэн байна.

2015 онд хийж гүйцэтгэсэн барилга угсралтын ажил, мян төгрөгөөр

Сум	Баг	Нэр	Хүчин чадал	Давхар	Нийт талбай	Барилга эхэлсэн огноо	Анхны төсөв
Сүмбэр	1	Сүмбэр сум ТЗын клубын хойд талд 100 хүүхдийн цэцэрлэг	100 хүүхэд	2	625	2013/07/01	452500
Сүмбэр	1	магнетитийн үйлдвэр	250 м2	1	250	2015/03/01	8820000
Сүмбэр	2	Аймгийн ОБ-ын контор, 8 н гал унтраах машины граш, 8 айлын орон сууц	8 айл	3	1296	2013/08/01	1597773
Сүмбэр	2	Эко сүмбэр хотхон 120 айл, 60 машины граш	120 айл	2	20000	2014/04/15	7500000
Сүмбэр	2	Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн хашаанд 100 хүүхдийн цэцэрлэг	100 хүүхэд	2	900	2013/08/28	1000008
Сүмбэр	2	Боржигон чуулгын их засварын ажил	500 суудал	2		2015/06/10	256795
Сүмбэр	2	Ханангийн эгнээг жишиг гудамж болгон засварлах	800 м	0	800	2015/07/20	150000
Сүмбэр	3	Аймгийн соёл, спорт, амралтын хүрээлэнд баригдаж буй хөл бөмбөгийн талбай	110 м2	0	110	2015/05/25	512500
Сүмбэр	3	Сүмбэр сумын нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн ажил	56 уртааш м	0	56	2015/04/13	63663
Сүмбэр	3	ХААА-ны хурлын залны засвар	30 м2	1	30	2015/03/02	24101.4
Сүмбэр	3	Нийтийн эзэмшлийн авто зам, зогсоолын ажил	2 км	0	200	2015/07/20	70000
Сүмбэр	3	Соёл амралтын хүрээлэнгийн тохижилтын ажил	500 м2	0	500	2015/07/10	470000
Сүмбэр	3	Хонхор хотхоны гадна дулааны шугамын засварын ажил	500 уртааш м	0	500	2015/07/30	37000
Сүмбэр	3	Нийтийн эзэмшлийн явган зам талбайн ажил	300 м	0	300	2015/07/30	50000
Сүмбэр	5	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүсийн цахилгаан хангамжийн ажил	300 уртааш м	0	300	2015/07/20	110000
Баянтал	1	Баянтал сумын уурын зуухны бүрэн шинэчлэл	100 м2	1	100	2015/04/17	628188
Баянтал	1	Баянтал сумын цэцэрлэгийн барилгын их засвар	100 м	2	100	2015/07/25	140000
Шивээговь	1	Угсармал 5 давхар 60 айлийн орон сууц	60 айл	5		2015/03/01	3000000

4. ТӨСӨВ САНХҮҮ, БАНК

4.1 2015 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 14467.0 сая төгрөг буюу 95.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг танилцуулбал:

	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Нийт орлого	15415.0	14467.0
Урсгал орлого	4504.8	4289.0
Татварын орлого	4219.8	3936.1
Татварын бус орлого	285.0	352.9
Хөрөнгийн орлого	-	0.7
Тусламжийн орлого	10910.2	10177.3

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд орлогын биелэлт 93.9 хувь, урсгал орлогын биелэлт 95.2 хувь, тусламжийн орлогын биелэлт 93.3 хувийн биелэлттэй байна.

Оны эцсийн байдлаар аймгийн хэмжээгээр 14929.2 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2627.8 сая төгрөг буюу 14.9 хувиар буурсан байна.

Төсвийн зарлагын 2015 оны гүйцэтгэлийг танилцуулбал:

	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Бүх зардал	16837.5	14929.2
Урсгал зардал	12750.7	11776.3
Хөрөнгийн зардал	4086.8	3152.9
Байгууллагын тоо	47	47
Ажиллагсадын тоо	751	751

2015 онд төсвийн зарлагын гүйцэтгэл 1908.3 сая төгрөг буюу 11.3 хувийн хэмнэлттэй гарсан байна.

Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр:

Өглөгийн үлдэгдэл 302.7 сая төгрөг

Авлагын үлдэгдэл 18.2 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үеийнхээс өглөг 20.6 дахин, авлага 1.6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

4.2. Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын эдийн засгийн үйл ажиллагааг 2015 оны эцсийн байдлаар танилцуулъя.

Банкуудын эдийн засгийн үзүүлэлт:

/өссөн дүнгээр/

дд	Үзүүлэлт	хн	Банкууд				Дүн
			Төрийн банк	ХААН банк	Хас банк	Капитал банк	
1	Салбар үйлчилгээний цэг	тоо	5	5	2	2	14
2	Цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид	хүн	5237	5730	5454	625	17046
3	Нийт ажиллагсад	хүн	29	31	13	7	80
4	Үүнээс : зээлийн эдийн засагч	хүн	6	10	3	1	20
5	Хадгаламж эзэмшигчид	хүн	3365	3937	5851	212	13365
6	Хадгаламжийн хэмжээ	сая.төг	2645.4	3576.6	3384	67.1	9673.1
7	Хадгаламжийн бүтээгдэхүүн	тоо	10	16	8	12	46
8	Хадгаламжийн дундаж хүү /сарын/	хувь	1.16	1.2	1.05	1.1	1.13
9	Зээлийн бүтээгдэхүүн	тоо	14	11	14	37	76
10	Зээлийн дундаж хүү	хувь	1.6	1.7	1.7	1.3	1.3
11	Зээл авсан : ААНБ	тоо	2	11	18	0	31
12	Иргэд	хүн	2339	3009	1883	727	7958
13	Малчид	хүн	125	240	0	0	365
14	Зээл олгосон : ААНБ	сая.төг	15.6	365.3	1210.0	0	1590.9
15	Иргэд	сая.төг	7959.8	19728.8	6690.0	162.7	34541.3
16	Малчид	сая.төг	352.5	1158.5	0	0	1511.0
17	Зээлийн эргэн төлөлт	хувь	99.7	98.4	97.6	92.8	97.1
18	Харилцахын тоо	тоо	18276	24489	2127	159	45051
19	Харилцахын дүн	сая.төг	1783.4	1492.8	184.0	27.1	3487.3
20	Карт эзэмшигчдийн тоо	хүн	8658	9789	4422	609	23478.0
21	Карт эзэмшигчдэд олгох хүүгийн хэлбэр	хувь	3.6	3.6	3.6	4.2	3.7
22	АТМ-н тоо	тоо	3	4	1	1	9

Банкны эдийн засгийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал хадгаламж эзэмшигчдийн тоо 1185 буюу 9.7 хувиар, хадгаламжийн хэмжээ 1239.1 сая төгрөг буюу 14.7 хувиар, зээл авсан аж ахуйн нэгжийн тоо 8 буюу 34.8 хувиар, аж ахуй нэгж байгууллагад олгосон зээлийн хэмжээ 149.3 сая төгрөг буюу 10.3 хувиар, зээл авсан иргэдийн тоо 806 буюу 11.3 хувиар тус тус өссөн бол иргэдэд олгосон зээлийн хэмжээ 5158.3 сая төгрөгөөр буюу 13.0 хувиар буурсан үзүүлэлттэй байлаа.

5. НИЙГМИЙН ДААТГАЛ, БУСАД ДААТГАЛУУД

5.1 Нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын сангийн орлого 2015 оны эхний 12 сард 7185.8 сая төгрөг, зарлага 8519.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 419.4 сая төгрөг буюу 6.1 хувиар, зарлага 990.4 сая төгрөг буюу 13.1 хувиар тус тус өслөө.

2015 онд нийт давхардсан тоогоор 1993 хүнд 6441.4 сая төгрөгийн тэтгэвэр, 2083 хүнд 814.2 сая төгрөгийн тэтгэмжийг цаг хугацаанд нь бүрэн олгожээ.

5.2 Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн эхний 12 сарын мэдээгээр 193 байгууллагын 5701 даатгуулагч иргэн, үүнээс 713 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуудагчдын цалин 37.0 тэр бум төгрөг, дундаж цалин 541.2 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн өмч оролцоотой 17 аж ахуй нэгжийн 1161 ажилтны цалин 10528.8 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 755.7 мянган төгрөг, орон нутгийн өмчийн оролцоотой 5 аж ахуй нэгжийн 224 ажилтны цалин 760.9 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 283.1 мянган төгрөг, төсөвт 50 байгууллагын 1499 ажилтны цалин 10347.6 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 575.3 мянган төгрөг, 7 ХКомпанийн 692 ажилтны цалин 7703.5 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 927.7 мянган төгрөг, 86 ХХКомпанийн 970 ажилтны цалин 3599.4 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 309.2 мянган төгрөг, бусад 23 байгууллагын 190 ажилтны цалин 687.4 сая төгрөг бөгөөд дундаж цалин нь 301.5 мянган төгрөг боллоо.

5.3 Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Монгол даатгал, Ард даатгалын компаниудаас жилийн эцсийн байдлаар мэдээг авч танилцуулбал :

/мянган төгрөг/

дд	Даатгалын бүтээгдэхүүний төрөл	2015 оны жилийн эцэс	
		Орлого	Олгосон нөхөн төлбөр
1	Тээврийн хэрэгслийн даатгал	50131.4	17504.2
2	Жолоочийн хариуцлагын даатгал	93964.9	51409.5
3	Эд хөрөнгийн даатгал	1556.8	1278
4	Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	0	0
5	Гэнэтийн ослын даатгал	15411.1	4114
6	Хүүхдийн гэнэтийн ослын даатгал	30	149.4
7	Гадаад зорчигчдын даатгал	47.1	0
8	Мэргэжлийн хариуцлагын даатгал	50	0
9	Ачаа тээвэрлэлтийн даатгал	6247.1	0
10	Хариуцлагын даатгал	784	0
11	Эрүүл мэндийн даатгал	22804.2	13953
12	Банкны зуучлалаар хийгдсэн даатгал	13067.3	701.6
13	Нийт	204093.9	89109.7

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад даатгалын нийт орлого 14.2 сая төгрөг буюу 7.5 хувиар, олгосон нөхөн төлбөр 25.7 сая төгрөг буюу 40.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

6. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР

6.1 Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын 2015 оны мэдээгээр зорчигч эргэлт 5304 мян.хүн км, тээвэрлэсэн зорчигч 22.1 мян.хүн, тээврийн орлого 12112.1 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс зорчигч эргэлт болон тээвэрлэсэн зорчигч 57.9 хувиар, тээврийн орлого 50.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна .

Авто тээврийн үндэсний төвийн
Говьсүмбэр аймаг дахь салбарын мэдээгээр:

/өссөн дүнгээр/

	Хэмжих нэгж	2014 он	2015 он
Зорчигч эргэлт	мян.хүн.км	3359.0	5304.0
Тээвэрлэсэн зорчигч	мян.хүн	14.0	22.1
Тээврийн орлого	мян.төг	8044.5	12112.1
Ажиллагчдын тоо	хүн	8	10

2015 оны байдлаар 3451 тээврийн хэрэгсэл техникийн үзлэгт орсон байна.

дд	Тээврийн хэрэгслийн төрөл	2014 он	2015 он
1	Бүгд	2847	3451
2	Суудлын	1508	1719
3	Автобус	95	108
4	Тусгай зориулалтын	149	309
5	Мотоцикл	210	202
6	Механизм	45	84
7	Чиргүүл	170	276
8	Ачааны автомашин	670	753

6.2 Аймгийн Холбооны газрын мэдээгээр 2015 оны эхний 12 сарын байдлаар нийт орлого 220.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 4.5 сая төг буюу 2.0 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 121.5 сая төг буюу 55.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 13.3 сая төг буюу 9.9 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт телефон цэгийн тоо 398 болж өмнөх оны мөн үеийнхээс 5 буюу 1.2 хувиар буурсан байна.

2015 оны эхний 12 сарын байдлаар интернэт үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 418 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 110 байна.

2015 онд 58 цахилгаан мэдээ гарсан нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7 дахин буурсан байна.

Аймгийн хэмжээгээр КТВ суваг 1272, телефон цэгийн тоо 398, үүнээс айл өрхөд 225 цэг ашиглагдаж байна.

6.3 Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын мэдээгээр манай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 554.2 мян.га байдаг бөгөөд нийт талбайн:

376819 га буюу 68.0 хувийг Сүмбэр сум

91606 га буюу 16.5 хувийг Баянтал сум

85755 хувийг Шивээговь сум эзэлж байна.

2015 онд нийт газрын:

481828.4 га буюу 86.9 хувийг - Хөдөө аж ахуйн газар

6037.7 га буюу 1.1 хувийг - Хот, тосгон, суурин газар

5114.1 га буюу 0.9 хувийг - Зам шугам сүлжээний газар

1538.0 га буюу 0.3 хувийг - Усан сангийн газар

59661.8 га буюу 10.8 хувийг -Улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж

байна.

Тайлант жилд нийт газрын 10035.4 га буюу 1.8 хувьд хохирол учирсан байна. Газарт учирсан хохирлыг ангилж үзвэл 10035.4 га буюу 94.8 хувь нь бэлчээр ба бусад суурин газар, 466.0 буюу 4.6 хувь хот тосгон бусад суурин газар, 29.8 га буюу 0.3 хувь нь усны сан бүхий газар, 27.3 га буюу 0.3 хувь нь ухаж эвдэрсэн газар тус тус эзэлж байна.

2015 онд нийт газар нутгийн 0.08 хувь буюу 453.1 га талбайд газар хамгаалах арга хэмжээ авсан байна.

Газрын төлбөр төлөлт, ноогдуулалтанд 96.1 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7 сая төг буюу 1.8 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

2015 онд 617 иргэнд 59.44 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүй өмчлүүлж, 0.17 га газрыг аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдан авсан байна.

7. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

Аймгийн татварын хэлтсийн бүртгэлээр 2015 онд 465 байгууллага үйл ажиллагаа явуулсан байна.

Дээрх аж ахуйн нэгж байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл:

▪ ХК	1
▪ ХХК	223
▪ ББН	4
▪ ЗБН	10
▪ Хоршоо	18
▪ Хадгаламж зээлийн хоршоо	1
▪ ОНӨҮГ	5
▪ Салбар байгууллага	60
▪ Төсөвт байгууллага	56
▪ ТББ	57
▪ Сан	9
▪ Төлөөлөгчийн газар	2
▪ Бусад /Шашин-5, ОНБ 14/	19

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал аж ахуй нэгж байгууллага 48 буюу 11.5 хувиар нэмэгдсэн байна.

8. БОЛОВСРОЛ

8.1 2015-2016 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 5 цэцэрлэг, хувийн өмчийн 4 цэцэрлэг нийт 9 цэцэрлэгийн 49 бүлэгт 1585 хүүхэд байгаагаас 199 малчдын хүүхэд хамрагдан хүмүүжиж байна. Цэцэрлэгийн бүлгийг тоогоор нь авч үзвэл яслийн бүлэг 1, бага бүлэг 13, дунд бүлэг 7, ахлах бүлэг 8, бэлтгэл бүлэг 9, холимог бүлэг 4, ээлжийн бүлэг 3, нүүдлийн бүлэг 4 байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 162 ажиллагсад байгаагаас 149 нь буюу нийт ажиллагсадын 91.2 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

Албан тушаалаар нь авч үзвэл:

- Эрхлэгч 9
- Арга зүйч 1
- Үндсэн багш 46
- Туслах багш 41
- Нягтлан бодогч 6
- Нярав 7
- Эмч 2
- Тогооч 16
- Үйлчлэгч 9
- Манаач, жижүүр 16
- Сантехникч 1,
- Бусад албан тушаалд 8 хүн тус тусажиллаж байна.

8.2 2015-2016 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 5 сургуулийн 121 бүлэгт 3301 сурагч суралцаж байгаагаас I-V –р ангид 1667 сурагч, VI-IX-р ангид 836, X-XII-р ангид 798 сурагч байна. ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй 26 сурагч суралцаж, дотуур байранд 135 сурагч амьдарч байна

2015-2016 оны хичээлийн жилд 384 хүүхэд 1-р ангид элсэн орсон байна. Насны ангиллаар нь авч үзвэл 5 настай 4, 6 настай 371, 7 настай 9 хүүхэд байлаа.

ЕБС-д 273 ажиллагсад үүнээс 222 нь буюу 81.3 хувь нь эмэгтэй байна.

Албан тушаалаар нь авч үзвэл:

- Захирал 5
- Сургалтын менежер 9
- Нийгмийн ажилтан 5
- Үндсэн багш 179
- Цагийн багш 2
- Байрны багш 2
- Нягтлан бодогч 3
- Нярав 5
- Архив бичиг хэрэг 5
- Номын санч 4
- Эмч 5
- Тогооч 4
- Сантехникч 2
- Цахилгаанчин 1
- Мужаан 1
- Үйлчлэгч 20
- Манаач, жижүүр 21 хүн тус тус ажиллаж байна.

179 үндсэн багш ажиллаж байгаа ба нэг багшид ногдох суралцагчийн тоо 18.4 байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал: Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо 69 буюу 4.5 хувиар, Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 257 буюу 8.4 хувиар нэг багшид ногдох суралцагч 1 буюу 0.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

9. ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ТАРИА

9.1 Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2015 оны эхний 12 сарын байдлаар 442 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 446 үүнээс 212 нь эрэгтэй, 234 нь эмэгтэй ба өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 46 буюу 9.5 хувиар, хүүхдийн тоо 45 буюу 9.2 хувиар тус тус буурсан байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 ба 1000 амьд төрөлтөд 13.4 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 6.4 промилоор нэмэгдсэн байна. Эхийн эндэгдэл, гэрийн төрөлт, бүртгэгдээгүй болно.

Он гарсаар 119733 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 10944 хүн буюу 84.5 хувиар өсч, 4568 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 186 хүн буюу 12.9 хувиар буурсан байна.

2015 оны эхний 12 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 6791 удаа гарч, халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 115, осол гэмтлийн өвчлөл 676 бүртгэгдсэн байна.

Эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2014 он	2015 он
Төрсөн эх	466	442
Амьд төрсөн хүүхэд	449	446
Амьгүй төрсөн хүүхэд	3	2
Жирэмсний эрт үеийн хяналт	-	87.7
Нялхасын эндэгдэл	7	6
5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл	7	7
Нийт нас баралт	77	81
Эмнэлгийн нас баралт	14	11
Хоног болоогүй нас баралт	7	4
Эмчлэгдсэн өвчтөн	5246	4568
Түргэн тусламжийн дуудлага	6540	6791
Осол гэмтлийн өвчлөл	630	676
Амбулаторын үзлэг	64886	119733
Халдварт өвчин	-	115

10. ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭ

10.1 Бизнес регистрийн санд худалдаа, үйлчилгээний салбарт 52 аж ахуй нэгж бүртгэгдсэнээс ҮСХ- ны батлагдсан хүрээгээр 17 аж ахуй нэгж байгууллага 2015 оны мэдээ тайланд хамрагдсан байна.

2015 оны мэдээллээр худалдааны салбарын орлого 20.1 тэрбум төгрөг, Тайлант хугацаанд борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг 18.1 тэрбум төгрөгт хүрснийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт орлого 11.6 тэрбум буюу 36.7 хувиар, борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг 11.5 тэрбум төгрөг буюу 39.2 хувиар тус тус буурсан байна.

Тайлант онд хүрээнд хамрагдсан 17 нэгжид 163 хүн ажилласан байна.

11. ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд эхний 12 сарын байдлаар 211 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үйлдэгдсэн гэмт хэргийн 92 нь буюу 43.6 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа . Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээ 6 буюу 2.8 хувиар буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдогсад 241, үүний 88 нь буюу 36.5 хувь нь ажилгүй иргэдийн үйлдсэн гэмт хэрэг байна. Гэмт хэрэгт холбогдогсодыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 4 буюу 1.7 хувиар өссөн байна.

Давхардсан тоогоор 1150 хүн эрүүлжигдэж, 243 жолооч эрхээ хасуулж, 140 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад эрүүлжигдсэн хүний тоо 288 буюу 20.0 хувиар, баривчлуулсан хүний тоо 75 буюу 34.9 хувиар тус тус буурч, жолооны эрх хасуулсан хүний тоо 6 буюу 2.5 хувиар өссөн үзүүлэлт гарлаа .

Гэмт хэрэг зөрчлийг төрлөөр нь танилцуулбал:

дд	Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо		Өсөлт бууралт	
		2014 он	2015 он	тоо	хувь
1	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	107	92	-15	-14.0
2	Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	3	4	1	33.3
3	Иргэдийн улс төрийн болон эрх чөлөө	2	1	-1	-50.0
4	Өмчлөх эрхийн эсрэг	72	74	2	2.8
5	Байгал хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	1	0	-1	-100.0
6	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	6	13	7	116.7
7	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4	1	-3	-75.0
8	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	19	2	11.8
9	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг				
10	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг				
11	Албан тушаалын гэмт хэрэг	4	0	-4	-100.0
12	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	0	-1	-100
	Бүгд	217	211	-6	-2.8

Гэмт хэрэг илрүүлэлт жилийн эцсийн байдлаар 78.8 хувьтай байна. Энэ онд онц хүнд гэмт хэрэг гараагүй, хүнд гэмт хэрэг 11, хүндэвтэр гэмт хэрэг 67, хөнгөн гэмт хэрэг 133 бүртгэгдсэн байна.

Гэмт хэргээс учирсан хохирол 1164.0 сая төгрөг, нөхөн төлүүлсэн нь 468.6 сая төгрөгт хүрсэн байна.

12. ЦАГ УУР

2015 онд агаарын температур өвлийн сард дунджаар 14.3 градус хүйтэн, хаврын сард дунджаар 3.4 градус хүйтэн, зуны сард дунджаар 16.7 градус дулаан, намрын сард дунджаар 12.4 градус дулаан байсан.

Энэ жилийг 2014 онтой харьцуулбал өвлийн сард 0.2 градусаар хүйтэн байсан бол хаврын сард 2.4 градусаар, зуны сард 0.6 градусаар, намрын сард 0.6 градусаар дулаан байлаа.

Хөрсний температур өвлийн сард дунджаар 15.5 градус хүйтэн, хаврын сард дунджаар 2.3 градус хүйтэн, зуны сард дунджаар 22.5 градус дулаан, намрын сард дунджаар 15 градус дулаан байсан.

2015 оныг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал өвөл, намартаа бага зэрэг хүйтэн, хавар, зундаа дулаан жил байлаа.

13. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Говьсүмбэр аймаг 2015 онд Улсын төсвийн болон аймаг, сумдын орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр нийт 71 төсөл, арга хэмжээг 3805.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Үүнд: нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 13, харьцуулалтын журмаар 29, шууд худалдан авах журмаар 23, шууд гэрээ байгуулах аргаар 1, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар 5 арга хэмжээ хамрагдаж байна.

Д.д	Хөрөнгө оруулалт	Тендер шалгаруулалтын журам						Төлөвлөгдсөн бараа үйлчилгээ	Зарлагдсан тендер	Төлөвлөгдсөн төсөв /сая.төг/	Гэрээлэгдсэн төсөв /сая.төг/
		НТШ	ХА	ШХА	ШГБ	ОНО	ЗҮ				
1	Улсын төсвийн	2	1	-	-	-		3	3	490.0	483.8
2	Аймгийн орон нутгийн хөгжил сан	3	10	7	1	-	4	25	25	1407.0	1323.2
3	Сумдын ЗДТГ-ын захиалгаар	1	-	-	-	-	-	1	1	150.0	146.5
4	Сүмбэр сумын орон нутаг сан	5	10	-	-	-	1	16	4	1164.5	252.8
5	Баянтал сумын орон нутаг сан	-	2	8	-	-	-	10	10	96.9	96.2
6	Шивээговь сумын орон нутаг сан	1	1	8	-	-	-	10	10	238.8	94.7
7	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал	1	4	-	-	-	-	5	5	186.8	185.5
8	Авто замын сан	-	1	-	-	-	-	1	1	71.5	70.9
	Нийт	13	29	23	1	0	5	71	59	3805.6	2653.7